

**2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 16-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ**

2022.05.16.

Дугаар 31

№	ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ТОВЧ АГУУЛГА	ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН	БИЕЛҮҮЛЭХ ХУГАЦАА	БИЕЛЭЛТ
4	Баяннуур сумын сургуулийн спорт заал, Сагсай сумын гүний худаг, Алтанцөгц сумын усжуулах талбайн ажлыг хийж, гүйцэтгэсэн “Нар-Маржан” ХХК-ний ажлын гүйцэтгэлтэй танилцах, дүнгэлт гаргах	МХГ-ын дарга Х.Бауыржан, ГХБХБГ-ын дарга К.Болат	V/19	-Баяннуур сумын спорт заалны барилга байгууламжийг аймгийн МХГ-тай хамт хяналт шалгалт хийж, үүрэг чиглэл өгсөн. -Сагсай суманд Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 25 сая төгрөгийн өртөгтэй Хар уулын гүний худагны хувьд газар дээр нь очиж танилцсан. Барилгын далд ажлын актаар 96м-ийн гүнтэй өрөмдмөл худаг байна. 2020 онд ХААГ-аас мэргэжлийн байгууллага ашиглалтад авсан. Улсын комисс ажиллаагүй байна. Ашиглах явцад тог зохицуулагч контрол багаж шатсан үүнийг гүйцэтгэгч байгууллага засаж өгсөн. Харин ашиглагч байгууллага техникийн нөхцөлд байхгүй пат-пад мотор авахаар шаардсан байна. Үүнийг гүйцэтгэгч байгууллага сайн санаа гаргаж пат-пад мотор олгохоор шийдвэр гаргажээ. Хил гаальтай холбоотой уг моторыг нийлүүлж чадаагүй байна. Усны гарцын

				<p>хувьд ямар нэгэн асуудал байхгүй.</p> <p>-Алтанцөгц суманд 39,4 сая төгрөгний өртөг бүхий хуучин усалгааны системийг сэргээн засварлах он дамжсан ажил байна. Гэрээний хугацаа 2022 оны 06 дугаар сарын 01-нд дуусах ёстой. Энэ хугацаанд ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. Нийт 4,5 км урттай. 45 хаалт хийсэн 500м газрыг хэсэгчилсэн чулуугаар бүрсэн байна. Зургийн дагуу хийгдэж байна.</p>
6	<p>Дэлүүн, Булган сумын хороондох Хар усны гүрийг яаралтай засварлуулах холбогдох арга хэмжээ авах</p>	<p>ГХБХБГ-ын дарга К.Болат</p>	V/19	<p>Дэлүүн, Булган сумын хороондох Хар усны гүрний асуудал манайд хамааралгүй асуудал байна.</p>

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР